



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 11/04

Эрдэнэт

Иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2023 онд үнэгүй өмчлүүлэх газрын байршил, хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ;

1. Аймгийн хэмжээнд 2023 онд иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэх газрын байршил, хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Иргэдэд газар өмчлүүлэх явцад хяналт тавьж, ажлын тайланг жил бүрийн 09 дүгээр сард багтаан аймгийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

